



ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД

МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН  
ТАМГЫН ГАЗАР

Ж.Самбуугийн гудамж 18, Чингэлтэй дүүрэг,  
Улаанбаатар хот 15170, Утас: 26 15 44,  
Цахим шуудан: info@supremecourt.mn

2024.06.18 № 05/3798

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Төсөл арга хэмжээний тухай

Монгол Улсын дээд шүүхийн Тамгын газраас зарласан УДШ/20240210203009 дугаартай Даатгалын үйлчилгээ төсөл, арга хэмжээний тендерт оролцогчоос ирүүлсэн тодруулгын дагуу тендер шалгаруулалтын баримт бичигт дараах өөрчлөлтийг оруулж байна. Үүнд:

ТШЗ	Тендерт оролцогчоос ирүүлсэн тодруулга	Тендерийн баримт бичигт орсон өөрчлөлт
ТШЗ 18.2	Тендерт оролцогчийн төлбөрийн чадварыг 2024 оны 1 дүгээр улирлын байдлаар 110-аас дээш хувь байна гэж заасан байна. Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн 559 дүгээр тогтоолоор Даатгалын төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлтийг тооцох аргачлал шинэчлэн батлагдсан тул одоо мөрдөгдөж байгаа аргачлалд нийцүүлж өөрчилж өгнө үү.	2024 оны 1 дүгээр улирлын байдлаар даатгагчийн төлбөрийн чадвар нь 1 дүгээр түвшинг хангасан байх. (Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн 559 дүгээр тогтоол "Даатгагчийн төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлт, түүнд тавигдах журам")
ТШЗ 26.1	Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь: Огноо: 2024 оны 06 дугаар сарын 19-ны өдөр Цаг: 10 цаг 00 минут	Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь: Огноо: 2024 оны 06 дугаар сарын 25-ны өдөр Цаг: 10 цаг 00 минут
ТШЗ 26.1	Тендерийн нээлтийг доор дурдсан хугацаанд цахим системээр хийх бөгөөд нээлтийн мэдээллийг оролцогч цахим системээр хүлээн авна. Огноо: 2024 оны 06 дугаар сарын 19-ны өдөр Цаг: 10 цаг 10 минут	Тендерийн нээлтийг доор дурдсан хугацаанд цахим системээр хийх бөгөөд нээлтийн мэдээллийг оролцогч цахим системээр хүлээн авна. Огноо: 2024 оны 06 дугаар сарын 25-ны өдөр Цаг: 10 цаг 10 минут

Иймд тендерт оролцогч нь өөрчлөлт оруулсан тендер шалгаруулалтын баримт бичгийн дагуу өөрийн тендерийг бэлтгэж ирүүлнэ үү.

ДАРГА



С.ЗАЯАДЭЛГЭР

151702000902